ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ТЭРГҮҮЛЭГЧИД, ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ, ЭРДЭМТЭН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА НАРЫГ СОНГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү журмыг Шинжлэх ухааны Академийн Тэргүүлэгчид, дэд ерөнхийлөгч, эрдэмтэн нарийн бичгийн даргад нэр дэвшүүлэх, тэднийг сонгоход мөрдөнө.

2. Энэ журам нь Монгол улсын Шинжлэх ухааны Академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3-ын 5 дугаар заалт, 6 дугаар зүйлийн 2 дахь заалтуудыг үндэс болгов.

3. Академийн Тэргүүлэгчид, дэд ерөнхийлөгч, эрдэмтэн нарийн бичгийн даргаар эрдэм судлалын ажлыг идэвхтэй хийж байгаа, академийн гишүүнийг буюу шинжлэх ухааны ёс зүйг хүндэтгэдэг эрдмийн зэрэг, цолтой эрдэмтнийг сонгоно.

Хоёр. Нэр дэвшүүлэх, нэр дэвшигчийг шалгаруулах

1. Академийн гишүүд ШУА-ийн Тэргүүлэгчид, дэд ерөнхийлөгч, эрдэмтэн нарийн бичгийн даргад нэр дэвшүүлэх саналаа Чуулган хуралдахаас 3 хоногийн өмнө ШУА-ийн Тэргүүлэгчдийн газарт бичгээр ирүүлсэн байна. Саналыг ирүүлэхдээ нэр дэвшигч эрдэмтдийн холбогдох материал /бүтээлийн жагсаалт, анкет, ажил байдлын тодорхойлолт/-ыг хавсаргасан байна.

2. Нэр дэвшигч нь хийх ажлынхаа гол чиглэлийг гаргаж бичгээр ирүүлсэн байна.

3. Шинжлэх ухааны Академийн Тэргүүлэгчид, дэд ерөнхийлөгч, эрдэмтэн нарийн бичгийн даргыг Академийн гишүүдийн саналыг нэгтгэн ШУА-ийн ерөнхийлөгч нэр дэвшүүлнэ.

Гурав. Сонгууль явуулах

1. ШУА-ийн Тэргүүлэгчид, дэд ерөнхийлөгч, эрдэмтэн нарийн бичгийн дарга нарын сонгох асуудлыг Их чуулганаас хэлэлцэж шийдвэрлэнэ.

2. Их чуулган нэр дэвшсэн эрдэмтдийн талаарх мэдээллийг сонсож хэлэлцэн нэрсийн жагсаалтад үлдээх эсэх талаар Академийн гишүүд саналаа хэлнэ. Нэрсийн жагсаалтад үлдээх эсэхийг Академийн гишүүдийн ил санал хураалтаар шийдвэрлэнэ.

3. ШУА-ийн Тэргүүлэгч гишүүдийг ил санал хураалтаар, дэд ерөнхийлөгч, эрдэмтэн нарийн бичгийн даргыг нууц санал хураалтаар сонгоно. Их чуулганд оролцсон гишүүдийн ердийн олонхийн саналыг авсан

тохиолдолд ШУА-ийн Тэргүүлэгч гишүүн, дэд ерөнхийлөгч, эрдэмтэн нарийн бичгийн даргаар сонгогдсонд тооцно.

4. Ердийн олонхийн саналыг шууд авч чадаагүй тохиолдолд хамгийн олон санал авсан 2 нэр дэвшигч болон тэдэнтэй тэнцүү санал авсан нэр дэвшигчийн нэрийг дараагийн санал хураалтын хуудсанд үлдээж, дахин санал хурааж ердийн олонхийн санал авсан нэр дэвшигчийг ШУА-ийн дэд ерөнхийлөгч, эрдэмтэн нарийн бичгийн даргаар сонгогдсонд тооцно.

5. Академийн гишүүн санал хураалтын хуудсанд бичигдсэн бүх нэр дэвшигчдээс дэд ерөнхийлөгч, эрдэмтэн нарийн бичгийн даргаар сонгох саналтай нэр дэвшигчийнхээ нэрийн өмнөх дугаарыг дугуйлж тэмдэглэнэ. Өөрөөр тэмдэглэсэн буюу нэгээс илүү нэр дэвшигчийн нэрийн дугаарыг тэмдэглэсэн тохиолдолд саналын хуудас хүчингүйд тооцогдоно.

6. Нэр дэвшигч бүрийн авсан саналын тоо, санал хураалтанд оролцсон гишүүдийн тоог баримтлан тооллогын дүнг гаргана.

7. Сонгуулийн тооллогын комиссыг 3-5 хүний бүрэлдэхүүнтэй илээр санал хурааж батална.

Тооллогын комиссын тогтоолыг Их чуулганаас илээр батална.

8. ШУА-ийн Тэргүүлэгч гишүүд, дэд ерөнхийлөгч, эрдэмтэн нарийн бичгийн дарга нарыг сонгосон тухай Их чуулган тогтоол гаргана.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ИХ ЧУУЛГАНЫ ТОГТООЛ

1998 оны 1 дүгээр сарын 08-ны өдөр | Дугаар 02 | Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн Их чуулганаас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн гишүүн сонгох сонгуулийн санал хураалтын журам"-ыг хавсралтаар баталсугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ Б. ЧАДРАА

ЭРДЭМТЭН НАРИЙН БИЧГИЙНДАРГА Т.ГАЛБААТАР